

АШИГТ МАЛГАМЛЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ХӨДӨЛМӨРИЙН ЦОУЛГУУ АЖИЛЛАГАА,  
ЭРҮҮЛ АХУЙН НӨ ЦӨЛ  
ЦУВРАЛ № 8

Улаанбаатар хот  
1998 он

### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

#### Нэг. Хөдөлмөрийн үндэслэл, тулгамдсан асуудлууд

Монгол улс дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагын дагуу олон хэвшил бүхий эдийн засгийг бий болгох зорилгыг хэрэгжүүлж байна. Өнөөгийн байдалаар материаллаг байлгийг бүтээх хүрээнд 30 гаруй мянган аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж тэдгээрт 769,6 мянган хүн ажиллаж байна. Өмч хувьчлал тодорхой хөтөлбөрийн дагуу явагдаж, аж ахуй эрхлэх үйл ажиллагаан дахь төрийн үүрэг, оролцох хэлбэр өөрчлөгдлөө. Хувийн бизнес эрхлэгчид бий болж эдийн засагт бие даасан хүч болон төлөвшиж байна. 1997 онд хийсэн үзлэг шалгалтаар аж ахуйн нэгж, байгууллагын дөнгөж 14,2 хувь нь хамтын гэрээтэй, 75,0 хувь нь хөдөлмөрийн дотоод журамтай, 57,1 хувь нь ажилчидтайгаа хөдөлмөрийн гэрээтэй ажиллаж байна. Үүнээс үзэхэд аж ахуйн нэгж, байгууллагууд зах зээлийн шинэ нөхцөлд хөдөлмөрийн харилцааны талаар тавигдаж байгаа шаардлагыг хангалтгүй биелүүлж байна.

Үйлдвэрлэл шинэ техник, технологи нэвтэрч урьд өмнө байгаагүй шинэ нэр төрлийн материал, түүхий эд, химийн бодисыг гадаад орноос өргөнөөр авч ашиглах хэрэгцээ, шаардлага өргөжлөө. Улсын үзлэгт хамрагдсан үйлдвэр, аж ахуйн нэгжид давхардсан тоогоор 10270 нэр төрлийн химийн бодис хэрэглэгдэж байгаа бөгөөд бодис хэрэглэдэг ажлын байрны 39,5 хувьд химийн бодисын ууршилт эрүүл ахуйн стандартаас их байна. Химийн бодисыг импортлох, тээвэрлэх, хадгалах, хэрэглэх, устгах ажлыг зохицуулах дүрэм, журам байхгүй, түүний хэрэглээ зарцуулалт, устгалд тавих бүртгэл тооцоо, хяналт аж ахуйн нэгж, байгууллага бүрт жигдэрч чадаагүй байна. Галын аюултай, тэсэрч дэлбэрэх бодис бүхий ажлын байрны 37,5 хувь нь уг бодисыг хадгалах зориулалтын байргүй, 22,4 хувь нь ашиглалтын заавар, дүрэмгүй байгаа нь үзлэгээр илэрлээ.

Үйлдвэрлэл, хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоо задарч, шинэ харилцааны эрх зүйн үндэс бүрэлдэж бий болоогүй, хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, журам, стандарт зөрчигдөх явдал газар авч хүний амь нас, эрүүл мэндийг хохиросон зөрчил, осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин нэмэгдэх хандлагатай байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хянан шалгах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, хяналтын байцаагч нарт ажлын байранд хэмжилт хийх багаж хэрэгсэл хүрэлцээгүй, шинжилгээ, судалгааны лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хэт хуучирснаас зохих хэмжээнд үйл ажиллагаа явуулж чадахгүй байна. Иймд хөдөлмөрийн нөхцөлийн байдалд хяналт тавьдаг байгууллагуудын лабораторийн материаллаг баазыг бэхжүүлж хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сэдвээр өргөн хүрээнд судалгаа, шинжилгээний ажил явуулах, мэдээллийн сүлжээг бий болгох нь тулгамдсан зорилт болж байна.

Засгийн газар, хадалмөрчдийн болон эздийн байгууллагын төлөөлөгчдийн гурван талт хэлэлцээрийг 1990 оноос эхлэн байгуулж, хөдөлмөрийн харилцаа, түүний дотор хөдөлмөр хамгааллын тулгамдсан асуудлыг шинэ нөхцөл байдалд шийдвэрлэх механизмыг бий болголоо.

#### Гарчиг

- 1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах Үндэсний хөтөлбөр 3
- 2. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм 14
- 3. Ашигт малтмалын ордыг ил аргаар олборлоход мөрдөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм-ээс 24
- 4. Мэдээ судалгааны маягт батлах тухай АМХЭГ-ын дарга, ГУУУХА-ны даргын тушаал 153/11 31
- 5. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай АМХЭГ-ын дарга, ГУУУХА-ны даргын тушаал 154/12 37

Сүүлийн жилүүдэд төв, орон нутагт хөдөлмөр хамгааллын албыг татан буулгаж орон тоог цомхотгох явдал газар авч аюулгүй ажиллагааг хангуулах, ажлын байрны эрүүл, аюулгүй нөхцөлийг сайжруулах асуудлыг хариуцдаг алба, ажилтангүй болсноос хөдөлмөр хамгааллын ажил доголдох явдал түгээмэл шинж чанартай болж байна.

1997 онд явуулсан улсын үзлэгээр нийт ажиллагчдын 18,7 хувь нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажлын байранд ажиллаж байгаагаас эрчим хүчний салбарт 58,8 хувь, уул уурхайд 47,1 хувь, барилгад 22,6 хувь, зам тээвэрт 19,1 хувь нь тус тус хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа нь тогтоогдлоо. Ажиллагсдын ахуй хангамжийн байрны хүрэлцээ, тохижилт туйлын хангалтгүй байна.

Аж ахуйн нэгж, байгууллагад ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн 65,6 хувь нь 10-аас дээш жил болж технологийн шаардлага хангахгүй байгаа ба бүрэн бус мэдээгээр сүүлийн гурван жилд аж ахуйн нэгжийн 8,4 хувь буюу 417 аж ахуйн нэгжид 832 удаа үйлдвэрлэлийн осол гарч, түүнд 866 хүн хамрагдсанаас 56 хүн нас барж, 59 хүн тахир дутуу болж, 810 хүн хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алджээ. Үйлдвэрлэлд гарсан ослын 71,9 хувь нь уул уурхай, хөнгөн хүнс, эрчим хүч, барилга, зам тээврийн салбарт байна. 1996 онд гарсан ослыг 1994 онтой харьцуулахад үйлдвэрлэлийн осолд өртсөн хүний тоо 1,3 дахин, түүнээс нас барсан хүний тоо 3,2 дахин өссөн байна. Үйлдвэрлэлийн ослын шалтгаан, нөхцөл, түүнээс учирсан хохирлын хэмжээг бүрэн тогтоох, гэм буруутай хүмүүстэй хариуцлага тооцох, цаашид гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ хангалтгүй байна. Улсын хэмжээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх талаар шинэ журмыг тогтоох шаардлагатай байна.

Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажил шаардлагын түвшинд хүрэхгүй байна. Үзлэгт хамрагдсан бүх аж ахуйн нэгж, байгууллагын дөнгөж 3,6 хувь нь цех, хэсгийн эмчтэй, 8,7 хувь нь эрүүл мэндийн ямар нэг байгууллагатай гэрээтэй ажиллаж, 36,7 хувь нь ажилчдыг анх ажилд авахдаа эмнэлгийн үзлэгт хамруулжээ. 1994 онд гарч байсан мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг 1996 онтой харьцуулахад 16,5 хувиар өсчээ. Мэргэжлээс шалтгаалах өвчнийг шалтгаанаар авч үзвэл тоосжилтоос үүссэн гуурсан хоолойн архаг үрэвсэл бүх өвчлөлийн 57,4 хувь, уушиг тоосжих өвчин /туберкулез/ 18,7 хувь, мэдрэлийн өвчин 6,1 хувь, химийн бодисын хордлогууд 8,2 хувийг тус тус эзэлж байна.

Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах талаар авч байгаа арга хэмжээний үр дүнг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бууруулах зорилттой нягт холбон авч үзэн шийдвэрлэж байх нь зүйтэй байна.

Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын 14,0 орчим хувьд нь ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгсэл олгогдоогүй, зарим ажлын хувцас, бие хамгаалах хэрэгслийн чанар шаардлага хангахгүй байгаагаас өмсөж, хэрэглэхгүй байна. Улсын хэмжээнд ажлын хувцас, бие хамгаалах хэрэгслийн стандартыг мөрдөх явдал туйлын дутагдалтай, ажлын хувцас, бие хамгаалах хэрэгслийн жагсаалтыг хөдөлмөрийн нөхцөлийг харгалзан баталж, мөрдөх явдал шаардлагаас хоцрогдож байна. Ажлын хувцасны үйлдвэр, цехийг боломжтой аж ахуйн нэгжүүд дангаараа буюу хөрөнгөө хоршиж байгуулах, угааж цэвэрлэх, нөхөн засаж сэлбэж ашиглах цех ажиллуулах замаар хангамжийг сайжруулах асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

#### Хоёр. Хөдөлмөрийн зорилго, үйл ажиллагааны чиглэл

1. Хөдөлмөрийн зорилго нь: Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн

аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, ажлын байрны хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангуулах, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бууруулахад оршино.

#### II. Хөдөлмөрийн зорилт:

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрх зүйн үндсийг бүрдүүлэн, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох.

2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, төв орон нутгийн хяналтын албаны ажилтны мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд судалгаа шинжилгээ хийх лабораторийн материаллаг баазыг бэхжүүлж, хөдөлмөрийн нөхцөлийг тодорхойлох шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах.

3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуйг сайжруулах ажилд Үйлдвэрчний Эвлэл, Эзлийн байгууллагын оролцоог дээшлүүлэх.

4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн сүлжээг бий болгож, мэдээллийн санг өргөжүүлэн хяналт, сургалт, судалгаа шинжилгээний ажлыг мэдээллийн бодитой эх үүсвэрт тулгуурлан гүйцэтгэх.

5. Тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр үйлдвэрлэл эрхлэх зарчмыг баримтлах.

6. Ажлын байранд хөдөлмөрийн эрүүл ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах.

7. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар удирдлага, ажиллагчид болон нийт иргэдэд мэдлэг олгох сургалтын тогтолцоог боловсронгуй болгох.

8. Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөлдөөс хамгаалж чадах стандартын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах.

9. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг баталгаажуулж, санхүүжүүлэхэд төв, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх.

#### Гурван. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа,

#### эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ

1. Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Үндэсний гурван талт хороо /орон тооны бус/, түүний салбар зөвдөлийн үйл ажиллагаанд оролцох оролцоог идэвхжүүлнэ.

2. Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэн дүрмийг тус тус шинэчлэн батална.

3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.

4. Хөдөлмөрийг сурталчлах, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллээр хүн амыг хангахад төр засгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өргөн оролцуулна.

II. Төрийн захиргааны төв байгууллага, агентлагуудаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам:

1. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дор дурдсан конвенцийг судалж, нэгдэж орох асуудлыг шийдвэрлүүлнэ:

- Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай 1947 оны 81 дүгээр конвенц
- Хөдөлмөрийн удирдлагын тухай 1978 оны 150 дугаар конвенц
- Ажлын байранд химийн бодис хэрэглэх үед аюулгүй байдлыг хангах тухай 1990 оны 170 дугаар конвенц.

2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай 1981 оны 155 дугаар конвенцийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи эрх зүйн харилцааг боловсронгуй болгож шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.

4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаархи дүрэм, журам, заавар, аргачлалыг шинэчлэн боловсруулна.

5. Хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага болон түүний нэгжийн удирдлага, хяналтын тогтолцоог нутаг дэвсгэрийн түвшинд оновчтой тогтоож үйл ажиллагааны нь эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

6. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тулгамдсан асуудлаар улсын хэмжээний болон бүс нутгийн, салбарын семинар, зөвлөлгөөн, үзүүлэх сургууль болон олон улсын симпозиум, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулна.

7. Мэргэжлээс шалтгаалах өвчнийг эрт оношлох, орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ.

8. Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдагсдад олгох нөхөн төлбөрийн тухай журмыг шинэчлэн боловсруулна.

9. Хөдөлмөрийн хяналтын албыг боловсон хүчин, материаллаг баазаар бэхжүүлнэ.

10. Гадаад орон, олон улсын байгууллагатай хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

11. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, стандартын үзүүлэлтийг хангаж, олон жил дараалан үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөл гаргаагүй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, хамт олныг урамшуулах механизм бий болгоно.

*Сангийн яам:*

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чухал ач холбогдол бүхий дараахь арга хэмжээнд улс, орон нутгийн төсвөөс хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

- Хөдөлмөрийн нөхцөлийн хүчин зүйлд хэмжилт, шинжилгээ хийх зориулалт бүхий лабораторийг өргөтгөх.
- Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч нарыг хэмжилтийн багаж хэрэгслээр хангах
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн Үндэсний мэдээллийн төвийг өргөтгөн гадаад, дотоодын мэдээллийн сүлжээнд холбох
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр боловсон хүчин бэлтгэн, мэргэжлийг дээшлүүлэх сургалт, семинар зохион байгуулах, гарын авлага, лавлах материал хэвлүүлэх

2. Төсөвт байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зардлыг тухайн жилийн төсөвт оруулан төлөвлөж байх тухай хууль эрхийн акт гаргаж мөрдүүлнэ.

*Гэгээрлийн яам:*

1. Үйлдвэрлэл, техникийн болон анагаах ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах, кабинет, лабораторийг шинэчлэн тоноглох, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, эмнэлгийн анхан шатны сургалтад шаардагдах орчин үеийн тоног төхөөрөмж, материаллаг баазтай болгох арга хэмжээг авна. Энэ чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийнэ.

3. АУИС-ийн сургалтын хөтөлбөрт мэргэжлээс шалтгаалах өвчнийг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх асуудлаар заах хичээлийн цагийг нэмэгдүүлж, энэ чиглэлээр эмч нарт нарийн мэргэжил эзэмшүүлнэ.

4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүмүүжил, сургалтын хөтөлбөрт осол, эндэгдлээс сэргэмжлэх, аюулгүй ажиллагааны арга барил эзэмшүүлэх, анхан шатны мэдлэг олгох асуудлыг холбогдох яам, мэргэжлийн байгууллагатай хамтарч боловсруулж хэрэгжүүлнэ.

*Дэд бүтцийн хөгжлийн яам болон Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам:*

1. Үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, тэдгээрийг ашиглалтад оруулах журмыг мэргэжлийн байгууллагатай зөвшилцөн боловсруулна.

2. Салбарын ажлын онцлогийг тусгасан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт, семинарыг зохион байгуулна.

3. Салбарын хэмжээнд мөрдөгддөг дүрэм, журам, зааврыг шинэчлэн боловсруулна.

4. Өргөх, зөөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам хоолойн баталгаажуулалтыг бүрэн хийнэ.

5. Салбарын хэмжээний үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран гаргаж тэдгээрийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6. Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах техник, зохион байгуулалтын арга хэмжээ авна.

*Байгаль орчны яам:*

1. Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж боловсронгуй болгоно.

2. Дээрх хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдох дүрэм, заавар, журмыг боловсруулж гаргана.

*Стандартчилал, хэмжисл зүйн үндэсний төв:*

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр мөрдөж буй бүх стандартуудад холбогдох газруудтай хамтран үзлэг, шүүлт хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хэмжилтийн багаж хэрэгслийг баталгаажуулдаг журам тогтооно.

III. Төрийн захиргааны хяналтын байгууллагуудын зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Дараахь дүрэм, журмыг шинэчлэн боловсруулна:

- Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм

- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөдийг бүртгэн судлах, мэдээлэх журам
- Ажиллагчдын эрүүл мэндийн цаг үеийн болон урьдчилсан үзлэгийн журам
- Хөдөлмөрийн тааламжгүй нөхцөлд ажиллагчдад хийжүүлсэн ундаа, бусад орлох бүтээгдэхүүнийг олгох журам

2.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад энэ тухай гэрчилгээ олгоно.

3.Ажлын байрны хөдөлмөрийн стандартуудыг аж ахуйн нэгж, байгууллагад мөрдүүлэн, зориулалтын бус байранд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, стандартын зөрчлөл гаргах явдлыг бууруулах талаар дэс дараалалтай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.Аймаг, бүс нутгийн түвшинд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, байцаагчдын сургалт, семинар зохион байгуулж мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэх ажлыг зохионо.

5.Ажил олгогч, удирдах ажилтан, ажиллагчдад хөдөлмөрийн харилцааны талаархи хууль тогтоомж, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, дүрэм, зааврын асуудлаар онол, практикийн мэдлэг, дадлага олгох төрөлжсөн хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулна.

6.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр гарын авлага, заавар, зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулж, аюулгүй ажиллагааны стандарт шаардлагад нийцсэн таних тэмдэг, дохио санамж хэвлэн сургалт сурталчилгаанд ашиглана.

7.Шинэ техник, технологи, тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгслийг шинээр үйлдвэрлэх, нэвтрүүлэх, ашиглахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэжлийн байгууллагаас зөвшөөрөл авдаг журмыг мөрдүүлж энэ чиглэлээр тавих хяналтыг сайжруулна.

8.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт хийх төвийн лабораторийн материаллаг баазыг өргөжүүлэн, боловсон хүчнээр бэхжүүлнэ.Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагчдыг хэмжилтийн багаж хэрэгслээр хангах арга хэмжээг авна.

9.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн Үндэсний төвийг өргөтгөн, мэдээллийн санг байнга шинэчлэн үйл ажиллагааг өргөжүүлэн гадаад, дотоодын мэдээллийн сүлжээнд холбон олон улсын мэргэжлийн байгууллагатай мэдээллийг шуурхай солилцож ажиллана.

10.Төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр зохиогдож буй ажил болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлийн өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилж, мэргэжлийн байгууллага, иргэдийг мэдээллээр хангах үр нөлөө бүхий мэдээллийн тогтолцоог бүрдүүлэн ажиллана.

**ҮҮ.Хөдөлмөрчдийн төлөөлөгчид, эздийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудын оролцоо**

*ҮЭ-ийн байгууллага:*

1.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн олон нийтийн хяналтыг эрчимжүүлж, ажиллагсдын дунд зохиох сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтай явуулна.

2.Аж ахуйн нэгж, байгууллагын дунд \* Эрүүл мэндийг дэмждэг, аюул осолгүй ажлын байр\* шалгаруулах уралдаан зохион явуулж дүгнэнэ.

3.Анхан шатны үйлдвэрчний байгууллагын идэвхтэн сонгуультай хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.

4.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн арга хэмжээг хамтын гэрээнд тусгаж биелэлтэд хяналт-тавина.

**Эздийн байгууллага:**

1.Тухайн салбар, байгууллагын ажлын онцлогт тохирсон ажлын тусгай хувцасны загвар зохион бүтээх уралдаан зарлаж, ажлын тусгай хувцасны үйлдвэр цехийг боломжтой аж ахуйн нэгж дангаараа буюу хөрөнгө хоршиж байгуулах ажлыг зохион байгуулна.

2.Хувийн хамгаалах хэрэгсэл үйлдвэрлэх уралдаан зарлаж тухайн үйлдвэрлэлийн эрхэлж буй жижиг, дунд үйлдвэрийг дэмжинэ.

3.Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн үзэсгэлэн худалдааг гадаад дотоодын сонирхогч байгууллагыг оролцуулан Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.Ажил олгогчдод хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу үе шаттайгаар зохион байгуулж, тэдний мэдлэг, арга барилыг дээшлүүлэх арга хэмжээ авна.

**Төрийн бус байгууллага:**

1.Зах зээл хөгжсөн орнуудад аж ахуйн нэгжийн удирдлага, инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтныг сурган, мэргэжлийг нь дээшлүүлэх ажилд зуучилна.

2.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр гарын авлага, зурагт хуудас, санамж, ном товхимол бэлтгэж хэвлүүлнэ.

3.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр хурал зөвлөлгөөн, уулзалт, ярилцлага зохион байгуулна.

4.Хөдөлмөр хамгааллын асуудлаар үр бүтээл, санаачилгатай ажилласан аж ахуйн нэгжийн удирдлага, инженер техникийн ажилтан, улсын байцаагчдыг шалгаруулан "Хөдөлмөр хамгаалал хөдөлгөөн"-ий дээд шагналаар шагнаж байна.

5.Аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр хамгааллын орчин үеийн сурталчилгааны кабинет байгуулахад арга зүйн зөвлөлгөө өгч туслана.

6.Аж ахуйн нэгж, байгууллагуудын хөдөлмөр хамгааллын инженер, мэргэжилтний мэдлэг, арга барилыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт явуулна.

**ҮҮ.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар:**

1.Эрсдэл ихтэй үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр авах арга хэмжээний дэд хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.

2.Нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтнуудад зориулан хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, журам, стандарт зэрэг асуудлаар сургалт зохион байгуулна.

3.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг /байцаагч/ ажилд томилох, чөлөөлөх асуудлыг мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэж байна.

**ҮҮ.Үйлдвэр, аж ахуйн нэгж, албан байгууллагын зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1.Үйлдвэрлэлийн онцлогт тохируулан техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.

2. Аж ахуйн нэгж байгууллагын захиргааны дэргэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг хариуцсан алба /ажилтан/-ыг ажиллуулж тэдний эрх, үүргийг тодорхой болгоно.

3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн байдалд судалгаа хийж, осол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулна.

4. Аюултай, хүнд нөхцөлтэй ажлын байранд ажилладаг ажилтнуудаа тусгай сургалт зохион байгуулж ажиллах эрх олгох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

5. Өөрийн боломжид тулгуурлан цехийн хэсгийн эмчтэй болох, эсвэл эмнэлгийн байгууллагатай гэрээтэй ажиллах замаар ажиллагсад эмнэлгийн үйлчилгээг ойртуулна.

6. Бүх төрлийн техник, тоног төхөөрөмж, өргөх, зөөх механизмын бүрэн бүтэн байдлыг хангаж, арчилгаа, үзлэг, засвар, үйлчилгээний чанарт хяналт тавьж ажиллана.

7. Ажлын байрны нөхцөлийг хэвийн хэмжээнд байлгахад анхаарал тавьж, үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах хэрэгслээр бүрэн хангана. Ажиллагсад хууль тогтоомжид заасан зохих хөнгөлөлт, урамшууллыг олгож байна.

8. Ахуйн байрыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хэмжээнд нийцүүлэн тохижуулж, тогтмол ажиллагаатай байлгана.

#### Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлснээр гарах үр дүн

Дээр дурдсан арга хэмжээг бүрэн, чанартай хэрэгжүүлдний үр дүнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн өнөөгийн түвшинд дор дурдсан чанарын ахиц өөрчлөлт гарна:

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрх зүйн үндэс бүрдэнэ.
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналт боловсронгуй болно.
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл сайжирна.
- Тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа дээшлэнэ.
- Химийн болон тэсэрч дэлбэрэх бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтад тавих хяналт сайжирна.
- Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанар, хангалтад ахиц гарна.
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт, сургалчилгаа, мэдээлэл, судалгаа, шинжилгээний ажил шинэ шатанд гарна.

Хөдөлмөрийн нөхцөл сайжрах, үйлдвэрлэлийн осол болон өвчлөлтийн тоо буурснаар хөтөлбөрийн үр дүн тодорхойлогдоно. Эдгээрийн үр ашиг нь урьд өмнө нь учирч болзошгүй байсан хүний амь нас, эрүүл мэнд, эдийн засгийн гарз хохирлын хэмжээтэй адил тэнцүү байх болно.

#### Тав. Хөтөлбөрийн удирдлага, санхүүжилт

##### 1. Хөтөлбөрийн удирдлага, үйл ажиллагаа:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний түвшинд удирдан зохицуулах, хянах, дүгнэх үйл ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Үндэсний зөвлөл гүйцэтгэнэ. Орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар зөвлөл хариуцна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн, бус байгууллагуудыг өргөнөөр оролцуулах, тэдний дэмжлэг туслалцааг авахад анхаарна.

Хөтөлбөрийг цаг үеийн шаардлага, бодит байдалтай уялдуулан баяжуулж ажил хэрэг болгох арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний болон нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, салбар, аж ахуйн нэгж, байгууллага /ажил олгогч/-ын түвшинд хэрэгжүүлнэ.

##### II. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцах байгууллага, гүйцэтгэх ажлын чиглэл

*Нэг. Яам, хяналтын улсын алба дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:*

##### 1. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

- Хөтөлбөрт тодорхойлсон зорилтыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн богино болон урт хугацааны үндсэн чиглэлтэй уялдуулан зохицуулж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, шийдвэрт тусгуулах;
- Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хянаж, тодотгон өөрчлөлт хийх;
- Хууль тогтоомж, стандарт, норм, нормативыг шинэчлэх, боловсронгуй болгох;
- Мэргэжлийн хяналтын байгууллагыг удирдан зохион байгуулж бэхжүүлэх;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн түвшин тогтоох;
- Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдсон мэдээлэл бэлтгэж холбогдох байгууллагад хүргэх.

##### 2. Салбарын яамд:

- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавин, үнэлэлт, дүгнэлт өгөх салбарын үйл ажиллагааг үндэсний түвшинд зохицуулах, зохион байгуулах;
- Хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн жил бүрийн чиглэл, улсын төвлөрсөн төсөвт тусгуулах;
- Салбарын хэмжээний бодлого тодорхойлох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх;
- Тодорхой төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд эзэд, хөдөлмөрчдийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газарт тайлагнах.

##### 3. Мэргэжлийн хяналтын улсын алба:

- Хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг орон нутаг /аж ахуйн нэгж/-т хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцож Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам болон Үндэсний хороонд тайлагнах;
- Хөтөлбөрт тусгасан тодорхой төсөл, арга хэмжээний биелэлийг зохион байгуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар сургалт, семинар хийх.

*Хоёр. Эзэд, хөдөлмөрчдийн байгууллага дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:*

- Хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар өөрийн гишүүдэд зөвлөмж, чиглэл өгөх, мэдээллээр хангах;
- Нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагатай хамтрах буюу дангаараа төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд олон нийтийн болон дотоодын хяналт тавих, мэдээлэл хийх, судалгаа гаргах.

*Гурав. Аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг дарга нар дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:*

- Үндэсний хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцож тайлагнах,
- Хөдөлмөрийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийг арилгахад зориулсан хөрөнгийг төсөл, арга хэмжээнд тусгаж үр дүнтэй зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих,
- Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдсон мэдээлэл, судалгааг бэлтгэж холбогдох байгууллагад хүргэн, хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар сургалт явуулах.

*Дөрөв. Аж ахуйн нэгж, байгууллага дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:*

- Үндэсний хөтөлбөрийг аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, биелэлтийг зохион байгуулах:
- Аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн төлөөлөл бүхий орон тооны бус зөвлөлийг хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох үүрэгтэйгээр ажиллуулах:
- Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн хамтын гэрээнд тусгаж эх үүсвэрийг баталгаажуулах.

### III. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг зайлшгүй шаардагдана. Тухайлбал хөдөлмөрийн нөхцөл тодорхойлох лаборатори болон мэргэжлийн хяналтын албыг бэхжүүлэх, ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, стандарт, норм, нормативыг боловсруулах, шинэчлэх, хэвлэн түгээх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаархи урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэргийг дурдаж болно. Хөтөлбөрийн санхүүжилтийг тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

Хавсралтад төвлөрсөн арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн арга хэмжээ тус бүрээр тодорхойлов.

### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТООЦОО

Арга хэмжээний нэр	Хугацаа	Шаардагдах хөрөнгө /сад, төг/	Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр		Галаад орон, ОУ Байгууллагын хөрөнгөөр
			Улсын төсөв	Орон нутгийн төсөв	
1. Хөдөлмөрийн нөхцөлийн төв лабораторийг өргөтгөн шинэчлэх		46.0	26.0		20.0
❖ Лабораторийн ширээ, тоног төхөөрөмж	1998	4.0	4.0		
❖ Багаж хэрэгсэл	1999	40.0	20.0		20.0
❖ Хямийн урвалж бодис	1998	2.0	2.0		
2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн Үндэсний мэдээллийн төвийг бэхжүүлэх арга хэмжээнд	1998	15.0	8.8		6.2
❖ Сургалтын тавилга тоног төхөөрөмж		12.5	6.3		6.2
❖ Бусад		2.5	2.5		
3. Байцаагч нарыг хэмжилтийн багаж хэрэгсэлээр хангах	1998-2000	195.1	35.1	80.1	80.0
4. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох багаж хэрэгсэл	1999	15.0	15.0		
5. Стандарт, норм, норматив, гарын авлага боловсруулах, хэвлүүлж түгээх	1998-2000	5.0	5.0		
6. Багш бэлтгэх, сургалт семинар зохион байгуулах	1998-2000	6.0	3.0		3.0
7. Сургалчиглаа, сэрэмжлүүлэг хийх	1998-2000	8.2	3.0	5.2	
8. Мэдээллийн сүлжээ бий болгох	1998-2000	40.0			40.0
9. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар төвийн болон бүсийн семинар хийх	1998	6.2	6.2		
<b>ДҮН</b>		<b>336.5</b>	<b>102.1</b>	<b>85.2</b>	<b>149.2</b>

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

1998 оны 08 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар А/214

Улаанбаатар  
хот

Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн 65 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм"-ийг 1 дүгээр, "Зочид буудалд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажилд баримтлах журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалаар баталсан дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, ажил олгогч нарт үүрэг болгосугай.

3. Энэ дүрэм батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 1992 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 85 дугаар тушаалаар батлагдсан "Улс, хоршоолол, олон нийт, хувийн үйлдвэрийн газар, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэлийн эрүүл ахуйг сайжруулах ажлыг зохион байгуулах дүрэм"-ийг хүчингүй болсонд тооцсугай.

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ХӨДӨЛМӨРИЙН  
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН АЖЛЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, ажилчдад сургалт, зааварчилга өгөх болон дотоодын хяналт тавих ажилд энэхүү дүрмийг мөрдөн ажиллана.

1.2. Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн хэлбэр харгалзахгүйгээр, тэрчлэн олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан аж ахуйн нэгж байгууллагад хамаарна.

1.3. Дүрмийн биелэлтийг нийт ажил олгогч хангаж ажиллах бөгөөд хөдөлмөрийн болон мэргэжлийн хяналтын албад, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавьж, зөрчил дутагдал гаргасан буруутай этгээдэд Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл  
ахуйн ажлын зохион байгуулалт

2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг аж ахуйн нэгж, байгууллага /цаашид ажил олгогч гэнэ/-ын дарга, эзэн, түүнтэй адилтгах албан тушаалтан шууд хариуцна.

2.2. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба, албан тушаалтныг /орон тооны болон орон тооны бус/-г томилж ажиллуулна /цаашид алба, ажилтан гэж нэрлэнэ/.

2.3. Албаны гишүүдийн тоог нийт ажилтны тооноос хамааруулан тогтооно.

2.4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах алба нь үйлдвэр, байгууллагын бусад албадтай адил статустай байх бөгөөд тус алба, албан тушаалтны гаргасан шийдвэр, шаардлагыг бусад албадын удирдлага, ажилтнууд заавал биелүүлэх үүрэгтэй.

2.5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба, албан тушаалтан нь хөдөлмөрийн тухай Монгол улсын хууль, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн актууд, энэхүү дүрмийг ажилдаа удирдлага болгоно.

2.6. Албаны гаргасан шийдвэрийг байгууллагын дарга, ажил олгогчоос эхлээд бусад албан тушаалтан заавал биелүүлэхийн хамт шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь албан ёсоор мэдэгдэж байх үүрэгтэй.

Гурав. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл  
ахуйн талаар ажил олгогч, алба, ажилтныг үйлдвэр, эрх

3.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн нөхцөлийг хангахад ажил олгогч дараахь үүрэг гүйцэтгэнэ.



а. Үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх техник, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах,

б. Ажилтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар мэдлэг олгох сургалт явуулах, аюулгүй ажиллагааны зааварчилга өгч, биелэлтэд хяналт тавих,

в. Ажилтныг ажилд шинээр ороход эмнэлгийн үзлэг хийлгэж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлуулсан байх ба тэднийг мэргэжлийн өвчин, арга хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн цаг үеийн үзлэгт зохих журмаар хамруулж, үйлдвэрийн эмнэлэг байгуулах, эмч, сувилалч орон тоогоор болон гэрээгээр ажиллуулах,

г. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг хангуулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн хамтын гэрээнд тусгах, зориулалтаар нь зарцуулах,

д. Ажилтанг эрхлэн гүйцэтгэсэн ажлын онцлогийг харгалзан ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгсэл, ариутгах, цэвэрлэх, угаах бодисоор үнэгүй хангахын хамт хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны жагсаалтыг баталж мөрдүүлэх,

е. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тухай тогтоосон журмын дагуу мэдээлэх, судлан бүртгэх, осол хордлого гарсан тохиолдолд анхны тусламж үзүүлэх хойшлуулшгүй арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

ж. Ажилтныг хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангасан ажлын байраар хангах, үйлдвэрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн найдвартай ажиллагаа, өргөх, тээвэрлэх, механизм, даралтат сав, шугам хоолойн баталгаажуулалтыг цаг хугацаанд нь хийлгэж байх,

з. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчдад хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасан хөнгөлөлт үзүүлж байх,

и. Аюулгүй ажиллагааны зааварчилгыг шинээр буюу шинэчлэн баталж мөрдүүлэхийн хамт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн асуудал хариуцсан алба, эсвэл албан тушаалтныг томилж ажиллуулах,

### 3.2. Ажил олгогч нь дараах эрхийг эдлэнэ:

а. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан албан тушаалтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх, албыг зохион байгуулах, орон тоо, ажиллах журмыг баталж мөрдүүлэх,

б. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний төсөв зардал санг батлах, хэрэгжилтэд хяналт тавих,

в. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм горимыг зөрчсөн ажилтнуудад хөдөлмөрийн хууль, байгууллагын дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэх,

### 3.3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба /албан тушаалтан/ дараах үүргийг гүйцэтгэнэ.

а. Үйлдвэрлэлийн бүх нэгжийн ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар гарсан хууль, дүрэм, заавар, журмын биелэлтэд шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах,

б. Үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны нөхцөл, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, хөдөлмөр хамгааллын стандартыг мөрдүүлэх,

в. Аюулгүй ажиллагааны зааварчилгыг шинээр буюу шинэчлэн боловсруулж батлуулах,

г. Ажилчин, албан хаагчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцсаар хангуулах,

д. Ажлын болон амралтын цагийн тохиромжтой горим тогтоох, засварлах, хооллох, эмнэлэг-ариун цэврийн нөхцөлөөр хангуулах,

е. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар сургалт зохион байгуулж явуулах,

ж. Хөдөлмөр хамгааллын нэгдсэн арга хэмжээг төлөвлөх, хөрөнгө зардлын хэмжээг тооцоход оролцож хамтын гэрээнд тусгуулах, биелэлтэд нь туслах,

з. Үйлдвэрлэлд гарсан осол, хурц хордлогыг тогтоосон журмын дагуу судалж бүртгэх, акт тогтоох, холбогдох газарт мэдээлэх,

и. Мэргэжлээс шалтгаалах өвчний байдалд судалгаа дүгнэлт хийж өвчлөлийг багасгах, эрүүлжүүлэх талаар арга хэмжээ авахуулах,

### 3.4. Дүрмээр өгөгдсөн үүргээ биелүүлэхийн тулд алба /албан тушаалтан/ нь дор дурдсан эрхтэй байна.

а. Хяналт шалгалт хийхдээ ажил хариуцсан албан тушаалтан, мэргэжлийн хүмүүс, ажилчдыг татан оролцуулах,

б. Байгууллагын захиргаа, бусад нэгж, хэсгийн удирдлага, ямар ч албан тушаалтанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага, хөдөлмөрийн тааламжтай нөхцөлийг буй болгох, гарч болзошгүй ослоос сэргийлэх арга хэмжээ авах талаар хугацаатай шаардлага тавьж биелэлтийг хангуулах,

в. Учирч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэхийн тулд шаардлагатай тохиолдолд захиргаатай тохиролцон аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй үйлдвэрлэлийн нэгж болон тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох,

г. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, журам, хууль зөрчсөн хүмүүс, албан тушаалтанд арга хэмжээ авах, хариуцлага хүлээлгэх талаар байгууллагын захиргаа, ажил олгогчид санал тавьж шийдвэрлүүлэх

### 3.5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар ажилтнууд байгууллагынхаа /ажил олгогчийн / өмнө дараахь үүрэг хүлээнэ.

а. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, дүрэм, заавар, технологийн горимыг чанд мөрдөх,

б. Ажил үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмшихийн хамт осол гэмтэл, мэргэжлийн хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул ослын үед анхны тусламж үзүүлж чаддаг байх,

в. Үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдах, ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар зөрчигдсөн тухай бүр ажил олгогчид яаралтай мэдээлэх,

г. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэнддээ сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй ажиллагааны заавар, дүрэмд заасны дагуу шуурхай арга хэмжээг авах,

д. Зохион байгуулалттай хийгдэж байгаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орж, эрүүл мэндээ хамгаалах,

е. Ажил олгогчоос олгосон ажлын хувцас бие хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэх,

### 3.6. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн нөхцөлийн талаар ажилтнууд дараахь эрх эдлэнэ:

а. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн нөхцөлийн талаар ажил олгогч хамтын болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй

тохиолдолд захиргаанд шаардлага тавих, ажил гүйцэтгэхээс татгалзах, холбогдох байгууллагад мэдээлэх,

б. Ажлын онцлогт тохирсон ажлын хувцас, ахуйн байр, хамгаалах хэрэгслээр хангуулах,

в. Хуулиар олгогдсон хөнгөлөлт эдлэх,

Дорov Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа,  
эрүүл ахуйн үндсэн шаардлага

4.1. Ажил олгогч нь хөдөлмөрийн стандартыг баримтлан ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлийг ажлын байр нэг бүрээр эрх бүхий байгууллагаар тогтоолгосны үндсэн дээр ажлын байрны нөхцөл, аюулгүй байдлыг стандартын шаардлагад нийцүүлэн хангах арга хэмжээг хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлнэ. Хөдөлмөрийн норм, стандарт өөрчлөгдсөн тохиолдолд үүнийг баримтлана.

4.2. Үйлдвэрийн зориулалтын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, өөрчлөн засварлахдаа хөдөлмөрийн хяналтын албаны зохих мэргэжлийн хүмүүсээр хянуулж баталгаажуулан зөвшөөрөл авсан байна.

4.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах ажлын байрны бүсийн агаарын бичиг цаг уур /агаарын температур, харьцангуй чийглэг, агаарын хөдөлгөөний хурд, дулаан / нь УСТ 12.013-91 /MNS/-д заасан хэмжээнд байна.

4.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний үндсэн ба туслах байрны өрөө тасалгааны гэрэлтүүлэг УСТ 12-013-91 /MNS/-ийн шаардлагад нийцсэн байвал зохино. Ажлын байранд байгалийн гэрэлтүүлгийн коэффициент 1.5 хувиас багагүй байна.

Гэрэлтүүлэг нь ажлын байрны талбарт жигд тархсан, гялбалт үүсгэхгүй байх шаардлагатай ба гэрэлтүүлэгчийн үүсгэврийг тогтмол хугацаанд цэвэрлэж байвал зохино.

4.5. Ажлын байрны дуу шуугианы хэмжээ нь УСТ-12-1-008-85 /MNS/-д заасан шаардлагыг хангасан байна.

Дуу шуугиантай тоног төхөөрөмжийн зөөлөвч жийрэг, битүүмжлэлийг тогтмол шалгаж, бүрэн бүтэн байлган, засвар үйлчилгээг тогтоосон хугацаанд гүйцэтгэж байвал зохино.

Дуу шуугиантай орчинд ажиллагчдад чихэвч хэрэглүүлэх ба ажлын дэглэм тогтоон ажиллуулах зэргээр чих дүлийрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна.

4.6. Ажлын байранд тоос, химийн бодисын ууршилтын хэмжээ нь УСТ-12-013-91 /MNS/-д заасан хэмжээнд байвал зохино. Ажлын байранд тоос, химийн бодис тархахаас сэргийлэн, салхивчийн ерөнхий ба хэстийн системийг төлөвлөх, ажлын үед агаар сэлгэх төхөөрөмжийг зориулалтын дагуу ажиллуулж байх, агаар сэлгэх төхөөрөмжийн ажиллагаанд тогтмол үзлэг хийж, эвдэрсэн тохиолдолд бүрэн засвар хийж, цэвэрлэж байвал зохино.

Ажлын байранд тоосжилтыг бууруулахад чиглэгдсэн чийглэх, битүүмжлэх арга хэмжээ авах ба тоостой хортой бодисыг тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах үед аюулгүй ажиллах нөхцөл бололцоог хангасан байна.

4.7. Цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн үүсгүүртэй харьцан ажилладаг ажлын байрны агаар байж болох цацраг идэвхт бодисын хэмжээ УСТ-12-051-91 /MNS/-д гадаргуудын бохирдолын хэмжээ УСТ УСТ-12-051-91 /MNS/-д заасан хэмжээнд тус тус байна.

4.8. Үйлдвэрлэлийн технологи, техникийн нөхцөл нь бичил цаг уурын зөвшөөрөгдөх хэмжээг хангах боломжгүй бол халуун агаараар хэсэгчлэн үлээх, агаарын ба усан хөшиг хийх, дулаацах байр бий болгох, амралтын дэгийг өөрчлөх, ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээ

авна. Хөдөлмөрийн таатай бус нөхцөлд ажилладаг ажиллагчдыг илчлэг, витаминлаг хоол хүнс, ундааны зүйлээр хангана.

4.9. Үйлдвэрлэлийн процесс нь УСТ 0012.3.001.82 /MNS/-д заасан аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагуудыг хангаж байх ёстой. Үйлдвэрлэлийн процесс нь хүрээлж байгаа орчин /агаар, хөрс, ус/-ыг бохирдуулахгүй байвал зохино.

4.10. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм заавартай, зохих журмын дагуу хөтлөгдсөн техникийн паспорттай байна. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагууд нь УСТ 012.2.001.81 /MNS/-г хангасан байвал зохино. Өргөх тээвэрлэх механизм, даралтат сав, шугам хоолойд тавигдах тусгай шаардлагыг ханган биелүүлнэ.

4.11. Техник, технологи, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн болон бие хамгаалах хэрэгсэл шинээр үйлдвэрлэх, нэвтрүүлэх, өөрчлөн засварлахад хөдөлмөрийн хяналтын байгууллагаас эдгээр зүйлсийг ашиглах зөвшөөрлийн гэрчилгээг авна.

4.12. Тогтмол гүйдлийн өндөр хүчдэлийн цахилгаан, тоног төхөөрөмж болон цэнэг хуримтлуулагч материалыг ашиглахад үүссэн цахилгаан тогтонги орон, үйлдвэрлэлийн давтамжтай цахилгаан орон, радио давтамжтай цахилгаан соронзон орон үүсгэдэг тоног төхөөрөмжтэй ажлын байрны хүчдэлийн түвшин УСТ 12.097-91, 12.101.91, 12.098-91 /MNS/-д заасан хэмжээнд тус тус байх ёстой.

4.13. Ажиллагчдын ахуйн байр нь ариун цэвэр, эрүүл ахуйн норм, стандартыг хангасан байна.

4.14. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь тухай ажил мэргэжлийн онцлогт тохирсон материалаар хийгдсэн хэв загвар нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан байна. Ажлын тусгай хувцасны чанарын үзүүлэлтийн жагсаалт, эдлэлтэй хувцас, хамгаалах хэрэгслийг шаардлагын дагуу угаах, ариутгах, цэвэрлэх нөхцөл боломжийг ажил олгогч хангасан байвал зохино.

Ажилтан бүр ажлын болон гадуур хувцсаа хадгалах хувцасны шүүгээтэй байна. Ажлын хувцастайгаа гудамж талбайд явах, гэр лүүгээ хувцсаа авч явахыг хориглоно. Бие бохирдуулах ажил үүрэг гүйцэтгэсэн ажиллагчид ажил дууссаны дараа шүршүүрт орж хувцсаа сольж байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

4.15. Эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүс, жирэмсэн эмэгтэйчүүдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны нөхцөлийг зохих байгууллагаар тодорхойлуулж, түүний биелэлтэд захиргаа хяналт тавихыг хамт тэдгээрийн өргөх, зөөх ачааны хэмжээнд хяналт тавьж ажиллана.

4.16. Бие засах газрын цэвэрлэгээнд хэрэглэгдэх шүүр, алчуур, хувин бусад цэвэрлэгээний хэрэгсэл нь бусад өрөөнийхөөс тусдаа байх ба ялгах таних тэмдэг тавигдсан байна.

Угаалга, цэвэрлэгээний ажлыг дуусмагц цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуурыг савантай халуун усаар угааж 1% хлорамины уусмалаар ариутгана.

Хуурай хог цуглуулах савыг таглаатай байлгаж, түүний орчны хөрс, бохирын цооног, ил задгай бие засах газрыг дулааны улиралд өдөр бүр хлорын шохойн 5-10% -н сүүн уусмалаар ариутган цэвэрлэж, хогоо тогтмол ачуулж байна.

4.17. Ажилтныг ажилд шинээр авах, ажиллах явцад хийх эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг ЭМНХ-ын сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу гүйцэтгэнэ.

4.18. Ажлын байранд болзошгүй ослын үед мэдээ дохио өгөх, тоног төхөөрөмжийг зогсоох автомат систем тавих зэрэг техник зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.19. Хүнд, хүчир ажлыг механикжуулах автоматжуулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх талаар арга хэмжээ авч, техник технологийн шинэчлэл хийх, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ.

4.20. Аж ахуйн нэгж, байгууллагын дэргэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, эм тариа, физик эмчилгээ, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа явуулах тасаг, хэсгийг ажиллуулж багаж, тоног төхөөрөмж, эмнэх боох материалаар хангана.

4.21. Аж ахуйн нэгж, байгууллага нь галын аюулгүй байдлыг хангах дотоод дүрэмтэй байх ба галын дохиолол, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлган галын аюулаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.22. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин хурц хордлого гарсан тохиолдолд тэдгээрийн шалтгааныг судлан тогтоох, арилгах талаар ажил олгогч нь холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа,  
эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа

5.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт нь доорх төрлөөс бүрдэнэ. Үүнд:

- а. урьдчилсан зааварчилгаа
- б. ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа
- в. давтан зааварчилгаа
- г. курсын сургалт

5.2. Зааварчилгын хөтөлбөр, хичээлийн сэдвийг аюулгүй техникийн асуудал хариуцсан албан тушаалтан боловсруулж, ҮЭ-ийн байгууллагатай зөвшилцөн захиргааны орлогч, ерөнхий менежер батлана.

5.3. Урьдчилсан ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа өгсөн тухай хяналтын хуудсыг ажилтан нэг бүр дээр хөтөлж хувийн хэрэгт нь хадгална /Хавсралт №1/

5.4. Шинээр ажилд орсон ажилтан, үйлдвэрлэлийн сургалт, дадлага хийхээр ирсэн оюутан сурагчдад ажилласан жил, боловсролын түвшинг харгалзахгүйгээр урьдчилан зааварчилгаа өгнө.

5.5. Урьдчилсан зааварчилгаар хөдөлмөрийн хууль тогтоом, дүрэм, заавар, улсын стандарт, тухайн байгууллагын өвөрмөц онцлог, байгууллагын дотоод дүрэм, аюулгүй техник, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэврийн дүрэм, галын аюулгүй байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хордлогоос урьдчилан сэргийлэх арга, осолдогчдод үзүүлэх анхны тусламжийн тухай асуудлуудыг тусгаж өгнө. Урьдчилсан зааварчилгыг хөдөлмөр хамгааллын кабинет юмуу буланд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан албан тушаалтан 2 цагаас багагүй хугацаагаар өгнө.

5.6. Ажилчин, албан хаагчдын ажилладаг цех, тасаг ажлын байр нь өөрчлөгдөх үед болон ажилд шинээр орсон хүмүүс, үйлдвэрлэлийн дадлага хийхээр ирж байгаа оюутан сурагчдад ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа өгнө.

5.7. Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаагаар доорх зүйлийг танилцуулсан байвал зохино. Үүнд:

- а. тухайн хүний ажлын байрны үйлдвэрлэлийн процесс ба гүйцэтгэх ажлын онцлог,
- б. аюулгүй ажиллагааны арга барилууд,
- в. хувийн хамгаалах хэрэгслүүд, тэдгээрийг ашиглах заавар,
- г. үйлдвэрлэлийн дотоод тээврийг хэрэгсэл ба өргөх зөөх машин механизм, тэдгээрийн ашиглалтын үед тавигдах аюулгүй техникийн дүрмийн шаардлага,

д. галын аюулгүй байдал, гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгслүүд, тэдгээрийг хадгалах ба ашиглах,

е. осолдогчдод үзүүлэх эмнэлгийн анхны тусламж,

5.8. Ажлын байран дахь анхан шатны зааварчилгыг тухайн цех, тасаг, хэсгийн дарга, эрхлэгч, биечлэн үзүүлэх журмаар өгнө.

5.9. Ажлын байран дахь анхан шатны зааварчилгын дараа зааварчилгыг тухайн цех, тасгийн дарга, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан албан тушаалтан бие даан ажиллуулах зөвшөөрөл олгоно.

5.10. Давтан зааварчилгаа нь ажилтны урьд олсон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор ажлын байран дахь анхан шатны зааварчилгын хөтөлбөрөөр өгөгдөнө. Тухайн цех тасаг, хэсгийн үйлдвэрлэл, технологи, тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгсэлд өөрчлөлт орох ба шинэчлэгдэх болон шинэ дүрэм заавар, норм стандарт мөрдөх үед давтан зааварчилгаа өгнө.

5.11. Давтан зааварчилгаа нь гурван хэлбэртэй байна. Үүнд:

- а. тодорхой хугацааны,
- б. төлөвлөгөөт бус,
- в. ажлын байран дахь өдөр тутмын.

Тодорхой хугацааны давтан зааварчилгыг салбарын онцлогийг харгалзахгүйгээр улиралд нэгээс доошгүй удаа өгч байна.

5.12. Төлөвлөгөөт бус зааварчилгаа нь хөдөлмөрийн нөхцөлд өөрчлөлт орох, шинэ технологи, тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгсэл нэвтрүүлэх үед тогтоогдсон хугацаанаас өмнө өгөгдөж байгаа давтан зааварчилгаа юм.

Аюулгүйн техникийн дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн хүмүүс буюу осол гарсан цех, тасаг, хэсгийн ажилчид 1 сараас илүү хугацаагаар хөндийрөн эргэж ажилдаа орсон тохиолдолд төлөвлөгөөт бус зааварчилгаа өгнө.

5.13. Онц аюултай болон аюултай ажил гүйцэтгэдэг хүмүүст ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа өгнө. Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа нь товч тодорхой байх ба ажил төрлийн үйлдэл эхлэхийн өмнө амаар буюу бичгээр өгөгдөнө.

5.14. Зааварчилгаа өгсөн тухай зааварчилгын бүртгэл хөтөлж байвал зохино.

5.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн курсын сургалтыг аж ахуйн нэгж, байгууллагад шинээр бэлтгэгдэж байгаа ажилчдын мэргэжлийн сургалттай хамтатган жил бүр явуулна.

5.16. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтад аж ахуйн нэгж байгууллагын цех, хэсгийн удирдлага, инженер техникийн ажилтнууд тодорхой хугацаанд хамрагдаж байвал зохино.

5.17. Өргөх, тээвэрлэх механизм, даралтат сав, хоолой зэрэг онцгой ажлын байранд ажиллагчдад тусгай хөтөлбөрөөр сургалт явуулж зохих байгууллагын үнэмлэх олгуулна.

5.18. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. /Хавсралт №2/

Зургаа. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа,  
эрүүл ахуйн хяналт

6.1. Аж ахуйн нэгж байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос хамаарч хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн байдалд тавих хяналтыг гурван шаттай зохион байгуулна. Нэгдүгээр шатанд цехийн доторхи тасаг, хэсэг, ээлж бригадад, хоёрдугаар шатанд цех болон үйлдвэр,

байгууллагын доторх нэгж хэсэгт, гуравдугаар шатанд байгууллагыг бүхэлд нь хамарч явуулна.

6.2. Анхан шатны хяналтыг тухайн хэсгийн ахлагч, мастер, ээлжийн дарга нар өдөр бүр ажил эхлэхийн өмнө, шаардлагатай үед /онцгой аюултай ажил гүйцэтгэх гэх мэт/ ажлын өдрийн дундуур хийнэ. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг анхан шатны хяналтын дэвтэрт тэмдэглэж, тэдгээрийг арилгах арга хэмжээг төлөвлөж, хариуцах, гүйцэтгэх ажилтан хугацааг тодорхойлно.

Гүйцэтгэлийг цехийн удирдлагад илтгэж байна.

6.3. Хоёрдугаар шатны хяналтыг сард 2-оос доошгүй удаа цехийн даргаар удирдуулсан комисс явуулна. Шалгалтын дүнг хяналтын хоёрдугаар шатны дэвтэрт тэмдэглэнэ. Энэ дэвтэр цехийн даргад хадгалагдана. Цехийн дарга нь хоёрдугаар шатны хяналтаар илрүүлсэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрмийн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг зохион байгуулах үүрэгтэй. Арга хэмжээний биелэлтийн явцыг цехийн дарга сар тутам хамт олондоо мэдээлж байна.

6.4. Гуравдугаар шатны хяналтыг байгууллагын дарга буюу ерөнхий менежерээр толгойлуулсан комиссоос улиралд нэг удаа явуулна. Томоохон үйлдвэрийг жилийн графикийн дагуу цех, объект тус бүрээр хэсэгчлэн шалгаж болно. Мөн ерөнхий мэргэжилтнүүдээр удирдуулсан групп болон хуваагдаж байгууллагын нэгж, хэсгүүдийг хуваарилан авч шалгалт хийж болно. Шалгалтын дүнг бүх цех, хэсгийн дарга нар оролцсон зөвлөгөөнөөр хэлэлцэж аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм хэм хэмжээг зөрчсөн хүмүүстэй хариуцлага тооцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг тодорхойлно. Шаардлагатай тохиолдолд байгууллагын дарга тушаал гаргана. Гуравдугаар шатны хяналтын дэвтэр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан албан тушаалтан дээр хөтлөгдөнө.

-----oO-----

## ЗААВАРЧИЛГЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

.....  
/аж ахуйн нэгж, байгууллагын нэр/

1. Овог нэр. ....
2. Төрсөн он. ....
3. Эмэгтэй, эрэгтэй. ....
4. Мэргэжил, тусгай мэргэжил. ....
5. Цех, тасаг, хэсэг, хэлтэс. ....
6. Урьдчилсан зааварчилга авагчийн албан тушаал, он, сар, өдөр гарын үсэг. ....
8. Зааварчилга өгсөн тухай тэмдэглэл: .....
9. Ажилдуулахыг зөвшөөрсөн хүний овог, нэр, албан тушаал, гарын үсэг .....
10. Ажилд томилсон шийдвэрийн утга, дугаар, он, сар, өдөр .....

Хавсралт №2

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ХӨТӨЛБӨР

Хичээлийн сэдэв	Цагийн тоо
Нэг. Ерөнхий асуудал	
1. Хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн харилцаа /хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, хамтын гэрээ/-ны асуудал	2 цаг
2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай үндсэн ойлголт, энэ ажлыг аж ахуйн нэгж, байгууллагад зохион байгуулах үйл ажиллагаа	2 цаг
3. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл	2 цаг
4. Үйлдвэрлэлийн осол, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	2 цаг
5. МШӨ, хурц ба архаг хордлого, хөдөлмөрийн чадвар түр алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ	2 цаг
6. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ	2 цаг
Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал	
1. Тухайн ажлын байрны аюулгүй ажиллагааны заавар	2 цаг
2. Тоног төхөөрөмжийн ашиглалтын үед тавигдах аюулгүй ажиллагааны шаардлагууд	2 цаг
3. Осол гэмтэлд үзүүлэх анхны тусламж	2 цаг
4. Цахилгааны аюулгүй ажиллагаа, цахилгаан гүйдэлд нэрвэгдсэн хүнд үзүүлэх анхны тусламж	2 цаг
5. Химийн бодис, материалтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа	2 цаг
Бүгд	24 цаг

Жич: Тухайн ажил мэргэжлийн онцлогоос хамааруулж заах сэдэв, цагийг өөрчилж болно.

-----oO-----

МОНГОЛ УЛСЫН ГЕОЛОГИ, ЭРДЭСИЙН БАЯЛАГИЙН САЙДЫН  
ЗӨВЛӨЛИЙН 1993 ОНЫ 18 ДУГААР ХУРАЛДААНААР БАТАЛСАН "АШИГТ  
МАЛТМАЛЫН ОРДЫГ ИЛ АРГААР ОЛБОРЛОХОД МӨРДӨХ АЮУЛГҮЙ  
АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮРЭМ" ЭЭС

Тавдугаар бүлэг

6.ГЭРЭЛТҮҮЛЭГ

\*383.Ил уурхайн гэрэлтүүлгийн шугам сүлжээ, түүнчлэн зөөврийн машин механизмуудын гэрэлтүүлэгт 220 В-оос ихгүй шугаман хүчдэлтэй тусгаарласан нейтраль бүхий цахилгаан хангамжийн сүлжээ хэрэглэнэ.Тусгай зориулалтын гэрэлтүүлгийн төрлүүдийг хэрэглэхэд 220 В-оос дээш хүчдэл ашиглаж болно. Зөөврийн гар гэрэлтүүлгийн тэжээлийн шугаман хүчдэл нь хувьсах гүйдэлтэй үед 36 В-оос тогтмол гүйдэлтэй үед 50 В-оос тус тус илүүгүй байх ёстой илүүгүй байх ёстой. Илчит тэрэгний зүтгүүрийн зөөврийн гэрэлтүүлэгт тогтмол гүйдлийн 75 В-ын хүчдэл хэрэглэж болно.

\*384.Тусдаа трансформаторын дэд станцаас тэжээгдэж байгаа ил уурхайн ажлын талбайн гаднах овоолгууд ба автозамын гэрэлтүүлэгт 380/220 В-ын газардуулсан нейтраль бүхий сүлжээ хэрэглэхийг зөвшөөрнө.

\*385.Ил уурхайн ажлын байруудын гэрэлтүүлэг нь № 4 дүгээр хүснэгтэд заасан гэрэлтүүлгийн норм хэмжээг хангаж байвал зохино.

\*386.Цахилгаанжсан төмөр замын 1650 В хүртэл хүчдэлтэй агаарын шугамын суурин ба зөөврийн шонгуудыг ашиглан тэдгээрийн авалцаат шугам сүлжээ байрлаагүй талд уг шугамаас дээш байрлалтайгаар гэрэлтүүлгийн утас татаж гэрэлтүүлэгчүүдийг байрлуулахыг зөвшөөрнө. Төмөр замын авалцаат шугам ба гэрэлтүүлгийн тэжээлийн утасны хоорондох босоо зай нь 1,5 метрээс багагүй байна. Гэрэлтүүлгийн тусгаарлагч лонхуудыг хамгийн их хүчдэлд ажиллаж (1650 В ) байхаар сонгосон байвал зохино.

Хүснэгт № 4

№	Ил уурхайн ажлын байр	Хамгийн бага гэрэлтүүлгийн хэмжээ ЛК	Гэрэлтүүлгийн норм тогтоосон талбай	Тайлбар
0	1	2	3	4
1.	Уулын ажил явагдах хэсгийн дэвсгар газар	0,2	Гэрэлтүүлэгдэж буй талбайн түвшинд	Гэрэлтүүлэх шаардлагатай хэсгүүдийг үйлдвэрийн ерөнхий инженер баталсан байна.
2.	Ил уурхайн догол мөргөцөгүүд ба овоолгуудад уул тээврийн машин тоног төхөөрөмж ажиллах ажлын байр талбай	5 10	Хэвтээ гадаргууд Босоо гадаргууд	Машин тоног төхөөрөмжийн ажлын тоноглолуудын үйлчлэх хүрээний бүх талбай, мөргөцөгүүд гэрэлтүүлэгдсэн байна.

0	1	2	3	4
3.	Гар ажиллагааны ажлын байр	5 10	Хэвтээ гадаргууд Босоо гадаргууд	
4.	Төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүн, автомашин, чиргүүлийн оволго дахь ачаа буулгах ажлын байр талбай, дамжуулан ачих хүлээн авах цэгүүд	3	Хэвтээ гадаргууд	Гэрэлтүүлж буй бүх түвшингийн хэмжээнд гэрэлтүүлгийг бүрэн хангасан байна.
5.	Бульдозер буюу бусад тракторын төрлийн машин ажиллах талбай	10	Тракторын гинжний түвшинд	
6.	Усан буу ажиллах ажлын байр талбай	5 10	Хэвтээ гадаргууд Босоо гадаргууд	Ашиглалт явагдаж буй доголын хамгийн өндөр цэг болон даралттай усны үйлчлэх бүх хүрээнд жигд гэрэлтүүлэгдсэн байх.
7.	Усан овоолгын шороо хүлээн авах талбай	5	Хэвтээ гадаргууд	
8.	Өрөмдлөгийн ажил явагдаж буй газар	10	Босоо гадаргууд	Өрмийн суурь машины цамхагийн дээд цэг хүртэл гэрэлтүүлэгдсэн байх
9.	Машин механизмын бүхээгт	30	Хэвтээ гадаргууд	Шалнаас дээш 0,8 м өндөрт
10.	Сорох төхөөрөмж байрлаж буй байр, ус хураагуурын орчимд	10	Хэвтээ гадаргууд	Байрны шалнаас 0,8 м өндөрт
11.	Олон утгуурт экскаватор болох овоолох байгууламж Тоноглолын ажиллах талбай, явах зам	10 15	Хэвтээ гадаргууд Босоо гадаргууд	Гэрэлтүүлэх шаардлагатай газрын хүрээг уулын ажлын паспортаар тогтоосон байна.
12.	Уулын машин механизмын засварын талбай	20 25	Хэвтээ гадаргууд Босоо гадаргууд	
13.	Туузан дамжуулга тасралтгүй ажиллагаатай шугам	5	Туузан гадаргуу	
14.	Туузан дамжуулгын хүрдэнд үйлчилгээ хийх хэсэгт	10	Хэвтээ гадаргууд	
15.	Туузан дамжуулгаас гараар ялгалт хийх хэсгүүдэд	50	Туузан гадаргууд	Чулуу ялгаж буй хүнээс цааш 1,5 метр хүртэлх зайд гэрэлтүүлэгдсэн байх
16.	Ажилчдын дулаацах байр	10	Хэвтээ гадаргууд	

0	1	2	3	4
17.	Догол хооронд тавигдсан шат гармуудал	3	Хэвтээ гадаргууд	
18.	Хүн байнга явах зам	1	Хэвтээ гадаргууд	
19.	Ил уурхайн доторх авто замд (хөдөлгөөний ачааллаас хамаарч) 0,5-3			Автомашин хөдлөх түвшинд гэрэлтүүлэгдсэн байх
20.	Ил уурхайн доторх төмөр замд	0,5	Хэвтээ гадаргууд	Замын дээд цогцос буй түвшинд гэрэлтүүлэгдсэн байх,

Хажуугийн байрлалтай татуурга бүхий шонгоос авалцаат шугам хүртэлх зай нь 1 метрээс багагүй байна. Тулгуур шонгуудад авалцаат шугам ба холбооны утсуудыг хамтад нь татахыг хориглоно. Гэрэлтүүлгийн шил, гэрэлтүүлэгчүүдийг солихдоо авалцаат шугамын хүчдэлийг бүрэн тасалсан нөхцөлд гүйцэтгэнэ. Гэрэлтүүлгийн тэжээлийн шугамд хийх засвар үйлчилгээ (дэгээ ба тусгаарлагчуудыг солих, утсуудыг чангалах гэх мэт)-ний ажлыг хийхдээ авалцаат шугам ба гэрэлтүүлгийн шугамын хүчдэлийг бүрэн салгасан байна. Эдгээр шугам сүлжээнд хийх ажлуудыг <<Үйлдвэр, албан байгууллагын цахилгааны тоног төхөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм >>-ийн дагуу гүйцэтгэнэ.

#### 7.ХАРИЛЦАА ХОЛБОО

\*387.Ил уурхай нь үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагааг хянаж удирдах болон аюулгүй ажиллагааг хангах зориулалтын иж бүрэн холбооны техник хэрэгслээр тоноглогдсон байх ёстой. Тусгай зориулалтын тээврийн хэрэгслийнхээс бусад дохиолол холбооны тоног төхөөрөмжүүд нь 220 В-оос ихгүй хүчдэлтэй гэрэлтүүлгийн шугам сүлжээнээс буюу тогтмол гүйдлийн зай хураагуур, шулуутгагч төхөөрөмжөөс тэжээгдвэл зохино. Төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориг ажиллагааны төвөөс (СЦБ) бусад 24 В-оос доош хүчдэл хэрэглэх дохиоллын шугамд бүрхүүлгүй утас хэрэглэж болно.

\*388.Ил уурхайн дэд станцууд нь зориулалтаасаа хамаарч эрчим хүчний болон уурхайн ерөнхий диспетчертэй телефон холбоотой байна.

Алслагдсан хэсгүүдэд ажиллаж буй экскаватор тээврийн хэрэгслүүд нь уулын диспетчертэй, галт тэрэгний зүтгүүрүүд нь төмөр замын диспетчертэй тус тус радио болон бусад хоёр талын холбоогоор холбогдсон байна.

\*389.Харилцаа холбооны төхөөрөмжүүд нь аянга, цахилган, сарнисан гүйдэл, өндөр хүчдэлийн авалцаат шугам сүлжээний аюултай нөлөөллөөс хамгаалагдсан байвал зохино.

#### НАЙМДУГААР БҮЛЭГ

#### ЭРҮҮЛ АХУЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД

#### 1.ТООС, ХОРТ ХИЙТЭЙ ТЭМЦЭХ

\*480.Ил уурхайн агаарын найрлага, хорт хольцын (тоос, цацраг идэвхжил, хорт хий г.м) хэмжээ нь эрүүл ахуйн шаардлагаар тогтоогдсон хэм хэмжээнд тохирч байх ёстой. Үйлдвэрийн ажлын байруудын агаарын найрлагын 20 хувийг

хүчилтөрөгч, 0,5-аас ихгүй хувийг нүүрсхүчлийн хий эзэлж болох ба бусад хорт хольцуудын хэмжээ нь хүснэгт № 5-д зааснаас хэтэрч болохгүй.

№	Хорт хольцын нэр	Хүснэгт № 5 Зөвшөөрөгдөх агуулгын хязгаар	
		Эзлэхүүний хувиар %/	М/куб/
1	Азотын ислүүд /NO <sub>2</sub> -ын хэмжээгээр/	0.00010	5.0
2	Нүүрстөрөгчийн исэл	0.0017	20.0
3	Хүхэрт үстөрөгч	0.00071	10.0
4	Хүхрийн ангидрид	0.00033	10.0
5	Акролейн /хишүүн тос/	0.00009	0.2
6	Фермальдгид	0.00004	0.5

\*481.Хорт хий гаргах эх үүсвэр (өөрөө шатах ашигт малтмалын шаталт, хорт хий ялгаруулах гүний ус, тэсэлгээний ажил, дотоод шаталтын хөдөлгүүрүүд г.м) бүхий ил уурхайнуудад энэхүү дүрмийн \*482 дугаар зүйлд заасан журмын дагуу ажлын байруудын агаарын байдалд хяналт тавина. Тэсэлгээ хийсний дараа агаарын хорт хольцын хэмжээ нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл багассан нөхцөлд, ил уурхайн ажлын байруудад хүмүүс орж ажиллахыг зөвшөөрнө.

\*482.Нүүрс хүлэр зэрэг шатамхай ашигт малтмал олборлох ил уурхайн хөрс хуулалт, ашигт малтмал олборлолт түүний нөөц бэлтгэх ажил, догол мөрөгцөгийн байдал зэрэг уулын ажлын гол зүүллэлтүүд нь гал гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан галыг шуурхай арилгах нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Шатамхай ашигт малтмалын хаягдал бүхий овоолгуудад гал гарахаас сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлбэл зохино.

\*483. Ажлын байрны агаарын найрлага дахь тоосжилтын хэмжээ нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнд заасан хязгаараас хэтэрч болохгүй.

\*484.Ил уурхайн агаарын хөдөлгөөн муутай буюу агаарын урсгал тогтонги хэсгийн агаарын солилцоог сайжруулах зорилгоор агааржуулалтыг идэвхжүүлэх арга хэмжээг тухайн нөхцөлд байдалд зохицуулан авч хэрэгжүүлбэл зохино.

\*485.Хорт хольцын ялгаралттай ил уурхайд тоос, хорт хий болон бусад хор нөлөөтэй үзэгдлүүдийг дарах, арилгах, агаарыг цэвэршүүлэх арга хэмжээг тэдгээрийн ялгаран гарч байгаа газар дээр нь зохион байгуулан авч хэрэгжүүлбэл зохино. Хэрвээ авч хэрэгжүүлсэн арга хэмжээ агаарын тоосжилтыг зохих хэмжээнд хүртэл багасгаж чадаагүй тохиолдолд экскаватор, өрмийн машины бүхээгт цэвэр агаар өгч бохир агаараас тусгаарлах хэрэгтэй.

\*486.Хий тоосны горимын онц хүндрэлтэй зарим ил уурхайнуудад хий тоос, агааржуулалтын албыг байгуулан ажиллуулвал зохино.

\*488.Чулуу огтлох машин, өрмийн машин, хийн ба цахилгаан гар өрмийн тоос баригчгүй буюу тоос намжаах төхөөрөмжгүйгээр ажиллуулж болохгүй.

\*489.Ангилан бутлах байгууламж болон уулын цулыг конвейерээс конвейерт дамжуулан ачихад үүсэх тоосыг хашлага хаалт, хоолойнуудаар орчны агаараас тусгаарлан сорж зайлуулбал зохино.

\*490.Дулааны улиралд конвейерээс чулууг гараар ялган зайлуулж байнга нөхцөлд тоос намжаах буюу тоосноос хамгаалах арга хэмжээ авах хэрэгтэй.

\*491. Хэрвээ гадны ямар нэг эх үүсвэрээс, тоосжилт буюу хорт хийн ялгарал үүсч байгаа бол түүнийг арилгах, багасгах арга хэмжээ авбал зохино.

\*492.Хүчтэй салхи буюу үлээлтийн улмаас догол, мөрөгцөгүүдийн болон овоолгын гадарга, нунтаглагдсан хөрс, чулуулгаас үүсэх тоосыг багасгахын тулд ил уурхайн тийм хэсгийг холбогч, барьцалдуулагч уусмалаар шүрших хэрэгтэй.

Энэ зорилгоор зөвхөн дуураймал хэргийг өгөгдсөөрх мод бут тарьж зүлэгжүүлж болно.

\*493. Нүүрс, хүлэр болон бусад шатах чанартай ашигт малтмалын давхаргад гал гарснаас үүсэх хорт хийгээр агаар бохирдуулах, ашигт малтмал шатаж үрэгдэхээс урьдчилан сэргийлж гал гарахаас хамгаалах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Гал гарсан нөхцөлд түүнийг унтраах арга хэмжээг яаралтай авбал зохино.

\*494. Ил уурхайд орж байгаа газрын гүний уснаас хорт хий ялгаран гарч байгаа тохиолдолд догол мөргөцөгүүдийн усны шүүрэлтийг бүрэн зогсоох буюу багасгах арга хэмжээ авах ёстой.

\*495. Үйлдвэрлэлийн хэрэгцээний ус татах шахуургын станцын ашиглах худаг цооногуудыг найдвартай хааж хамгаалсан байх хэрэгтэй.

\*496. Засвар үйлчилгээ, хийхээр ажилчдыг худагт оруулахын өмнө усыг бүрэн шавхан гаргаж, сайтар агааржуулан, ээлжийн мастер, буюу ахлагчийг байрлуулж хорт хийн агуулагад хэмжилт хийсэн байвал зохино.

\*497. Хэрвээ худагт хорт хий байгаа нь илэрсэн буюу хүчилтөрөгч нь байвал зохих хэмжээнд хүрээгүй нөхцөлд тэнд хийгдэх засварын бүх ажлыг зөвхөн хорт хийгээс хамгаалах баг хэрэглэн гүйцэтгэх хэрэгтэй.

## 2. АРИУН ЦЭВЭР АХУЙН БАЙР

\*498. Ил уурхай бүрт буюу хэд хэдэн уурхайн дунд захиргаа-аж ахуйн үйлчилгээний байр бэлдэж тоногдсон байвал зохино.

Ахуйн үйлчилгээний байр нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн тус тусдаа тасалгаатай байх бөгөөд хүч чадлыг нь ил уурхайн хүч чадлаа бүрэн эзэмших үеийн ажиллагчдын тоогоор нь тогтоосон байх хэрэгтэй.

Ахуй үйлчилгээний байрны бүрэлдэхүүнд: цэвэр ба ажлын хувцасны тасалгаа, ажлын хувцсыг угаах, хатаах өрөө, халуун ус, бие засах газар, ажлын хувцас, гутлыг засварлах өрөө, гутал угаах, цэвэрлэх өрөө, уух усыг буцалгаж бэлтгэх газар, амь хамгаалах баг олгох тасалгаа, эмэгтэйчүүдийн соёл ахуйн өрөө, эмнэлгийн цэг орно.

Захиргаа ахуйн үйлчилгээ, гуанз, эмнэлгийн цэгүүд нь нүүр, хүдэр нөөцлөх талбай, ачилтын цэг, ангилан бутлах цех зэрэг тоосжилт ихтэй барилга байгууламжаас 50 м-ээс багагүй зайтай салхины дээд талд, харин үндсэн үйлдвэрлэлийн барилга байгууламжаас 500 м-ээс ихгүй зайд байрласан байвал зохино. Эдгээр барилга байгууламжийн эргэн тойронд мод бут суулгаж тарьсан байх нь зүйтэй. Тайлбар:

1. Ажилчдыг тусгай унаагаар уурхайд зөөвөрлөн хүргэдэг нөхцөлд захиргаа-ахуй үйлчилгээний барилга нь ил уурхайгаас алс зайдуу байж болно.

2. Бага хүч чадлын уурхайнуудад ариун цэврийн хяналт тавих байгууллагуудтай зөвшөөрөлцсөний үндсэн дээр ариун цэвэр-ахуйн байрны бүрэлдэхүүнийг өөрийн нөхцөлд байдал боломжид зохицуулан өөрчлөн багасгаж болно.

\*499. Халуун усны хүлээн авах чадлыг хамгийн их хүнтэй ээлжийн ажиллагсдын усанд орох хувцсаа сольж өмсөх хугацаа нь 45 минутаас ихгүй байхаар тооцоолон тогтоосон байвал зохино.

\*500. Халуун усны усанд орох нэг шүршүүр нь цагт 500 л халуун ба хүйтэн усаар хангахаар тооцоологдсон байх бөгөөд холигч ба тохируулагч хаалтуудтай байх хэрэгтэй.

Халуун усанд хэрэглэх усны чанарыг Улсын эрүүл ахуйн хяналтын байгууллагатай зөвшөөрөлцсөн байвал зохино.

\*501. Халуун ус, хувцас солих өрөө, тасалгаануудын шал нь халуун усаар угааж цэвэрлэхэд хялбар, ус чийг даах чадвартай, гулгаж хальтирахааргүй материалаар хийгдэх бөгөөд хана ба хаалтууд нь 2,5 м хүртэл өндөрт ус чийг даах материалаар өнөгөлөгдсөн байвал зохино. Энэ өрөө тасалгаануудад шал ба ханыг угаахад зориулагдсан зөөлөн хоолой бүхий усны цорго хаалт байх хэрэгтэй.

\*502. Ариун цэвэр-ахуй үйлчилгээний байрууд нь бохир агаарыг цэвэрлэж байх зориулалтын агааржуулах сэнстэй байвал зохино.

## 3. ҮЙЛДВЭРЛЭЛ-АХУЙН БАЙР

\*503. Хэсэг бүхэн ажлын байраас 300 м-ээс холгүй зайд дулаацх байруудыг барьж ашиглах бөгөөд эдгээр байрууд нь ширээ, сандал, угаагуур, устай сав, өлгүүр зэргээр тоноглогдсон байвал зохино. Байрны доторх агаарын дулаан нь 20<sup>o</sup>C-ээс багагүй байх хэрэгтэй.

\*504. Экскаватор, өрмийн машин болон бусад машин тоног төхөөрөмжийн бүхээг нь дулаалагдсан, аюулгүй шаардлагыг хангах дулаацуулах хэрэгслээр тоноглогдсон байвал зохино.

\*505. Ил уурхайнуудад ариун цэврийн шаардлагыг хангасан бие засах газруудыг байгуулсан байх хэрэгтэй.

\*506. Үйлдвэр бүр сард 2-оос доошгүй удаа ажлын хувцсыг угаах, засах ажлыг зохион байгуулж байвал зохино.

## 4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

\*507. Ил уурхай бүрт буюу ойрхон орших хэд хэдэн уурхайн дунд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх цэгийг байгуулж ажиллуулбал зохино.

Эмнэлгийн цэгийг зохион байгуулах, төхөөрөмж хэрэгслээр хангах арга хэмжээг орон нутгийн эрүүл мэндийн газартай зөвшөөрөлцөн гүйцэтгэх хэрэгтэй.

300-аас бага ажиллагчидтай үйлдвэр, уурхайнуудад эмнэлгийн үзлэг хяналтыг ойролцоо орших эмнэлгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно. Хэсэг цехүүд, драг, хөвөгч, экскаватор болон уул тээврийн үндсэн тоног төхөөрөмж бүр нь эмнэлгийн анхны тусламж үзүүлж болох наад захын эм, материал бүхий аптектэй байвал зохино.

\*508. Бүх хэсэг цехүүд болон драгууд өвчтөнийг эмнэлгийн анхны тусламж үзүүлэх цэгт хүргэж өгөх зориулалтын дамнуургатай байх хэрэгтэй.

\*509. Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх цэг бүрт гэнэт өвчилсөн буюу осолдож гэмтсэн хүмүүсийг ойролцоох эмнэлгийн газруудад хүргэж өгөх зориулалтын аваарийн машин байх бөгөөд түүнийг зориулалтын бус ажилд хэрэглэхийг хориглоно. Аваарийн машин нь өвлийн улиралд осолдогч, өвчлөгчдийг хучих дулаан хувцас, одъяалтай байна.

\*510. Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх цэгүүд нь харилцах угтастай байвал зохино.

## 5. УСАН ХАНГАМЖ

\*511. Бүх уурхай, үйлдвэрүүд нь ажиллагчдыг сайн чанарын хэрэгцээт ундааны усаар хангах ёстой.

\*512. Ундааны усны эх үүсвэрт тогтмол хими-бактериологийн шинжилгээ хийж хэрэглэх шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлж байвал зохино.

Хүмүүсийн ахуй хэрэглээний усыг зөвхөн Ариун цэвэр, халдвар судлалын Улсын хяналтын газраас тусгайлан зөвшөөрөл олгосон нөхцөлд хэрэглэж болно.

\*513.Ахуй-хэрэглээнд зориулагдсан усыг цэвэршүүлэх арга, уурхайн ашиглахын хил дотор байгаа ус хангамжийн эх үүсвэрийг Улсын ариун цэврийн хяналтын байгууллагатай зөвшөөрөлцсөн байх ёстой.

\*514.Гадаргуугын усны эх үүсвэрийн ус хангамжийн байгууламж, болон ус хуримтлуулах цооног, байгууламж нь бохирдолтоос хамгаалагдсан байвал зохино.

\*515.Ундааны усыг бэлтгэн тоноглол дээр ажиллах хүмүүс нь эмнэлгийн үзлэгт орж ариун цэврийн нормын дагуу шинжилгээ хийдгэсэн байвал зохино.

\*516.Ундааны усыг цайрдсан төмөр савд буюу Улсын ариун цэврийн хяналтын байгууллагатай зөвшөөрөлцсөний үндсэн дээр цэвэрлэх, ариутгах, боломжтой бусад материалаар хийгдсэн савд хадгалах ёстой.

Ундааны ус жийх сав нь бохирдлоос хамгаалсан түгжээ бүхий тагтай цоргогой байхаас гадна 7 хоногт нэг удаа халуун усаар угааж ариутгадаг байх ёстой.

----- оОо -----

## АМХЭГ-ЫН ДАРГА, ГУУУХА-НЫ ДАРГЫН ХАМГАРСАН ТУШААЛ

1998 оны 7 дугаар  
сарын 9-ны өдөр

Дугаар 153/11

Улаанбаатар хот

Мэдээ, судалгааны маягт батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн байдалд судалгаа дүгнэлт хийж "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах" Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалтыг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. "Үйлдвэрлэлийн ослын мэдээ"-ний маягтыг 1 дүгээр хавсралт "Хөдөлмөр хамгааллын хувцас, бие хамгаалах хэрэгслийн олголтын мэдээ-ний маягтыг 2 дугаар хавсралт "Хөдөлмөр хамгааллын ажлын зохион байгуулалт, сургалт ахуй хангамж, эмнэлэг үйлчилгээний ажлын судалгааны маягтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан маягтын дагуу мэдээ, судалгааны материалыг тогтоосон хугацаанд авч дүгнэлт, санал боловсруулан хэрэгжүүлэх ажил зохион байгуулахыг Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын Уул уурхайн албаны захирал /Ц.Энхболд/, ГУУУХА-ны улсын байцаагч /Г. Жигжидсүрэн/ нарт даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай уялдуулан Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын дарга ГУУУХА-ны даргын 1997 оны 45/08 тоот тушаалаар батлагдсан магта № 12-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  
Д.ЖАРГАЛСАЙХАН

ДАРГА  
Д.ЧИЛХААЖАВ

----- оОо -----



Уурхайн \_\_\_\_\_ оны  
 үйлдвэрлэлийн ослын мэдээ

Үзүүлэлт	Д/д	Онд	Онд	Харьцуулсан хувь
01	02	03	04	05
Ажиллагсдын дундаж тоо	01			
Үүнээс: эмэгтэйчүүд	02			
Осолд өртсөн нийт хүний тоо	03			
Үүнээс: эмэгтэйчүүд	04			
Гарсан нийт ослын тоо	05			
Үйлдвэрлэлийн осолд оруулсан хүчин зүйл	Машин, механизм, тоног төхөөрөмжөөс	06		
	Тээврийн хэрэгслээс	07		
	Өргөх, зөөх төхөөрөмжөөс	08		
	Цахилгаан гүйдэлд цохиулснаас	09		
	Халаалт, түлэгдэлт, хөлдөлтөөс	10		
	Уналт, нуралтаас	11		
	Адгуус, амьтанд өртсөнөөс	12		
	Хими, физиологийн сөрөг хүчин зүйлсийн үйлчлэлээс	13		
	Бусад хүчин зүйлээс	14		
	Үйлдвэрлэлийн ослын шалтгаан	Машин механизм, тоног төхөөрөмжийн гэмтлээс	15	
Тоног төхөөрөмжийн хийцийн алдаанаас		16		
Технологи процессын горим зөрчсөнөөс		17		
Аюулгүй ажиллах арга барилд хангалтгүй сургаснаас		18		
Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлгүйгээс		19		
Ажилчдыг мэргэжлийн дагуу ажиллуулаагүйгээс		20		
Гэрэлтүүлэг хангалтгүйгээс		21		
Бусад		22		
Үйлдвэрлэлийн осолд өртөгсдийн насны ялгаа	14-15 настай	23		
	16 настай	24		
	17 настай	25		
	18-35 настай	26		
	35-аас дээш	27		
Осолд өртөгсдийн ажил-	5 хүртэл жил	28		
	5-15 жил	29		

ласан хугацаа	15-аас дээш жил	30		
Үйлдвэрлэлийн ослоор хөдөлмөрийн чадвараа түр алдсан хүн		31		
Үүнээс	Ажлын 1-6 өдөр	32		
	Ажлын 7 ба түүнээс дээш өдөр	33		
Нас барсан хүн		34		
Тахир дутуу болсон хүн		35		
Тахир дутуу болж мэргэжлийн ажлаас бөр ажилд шилжсэн хүн		36		
Байгууллагаас нөхөн төлбөр авдаг хүний тоо		37		
Нэг хүнд сард олгож буй нөхөн төлбөрийн дундаж хэмжээ төг		38		

МЭДЭЭ ГАРГАСАН:

1.Ерөнхий инженер.....

2.Хөдөлмөр хамгааллын асуудал

хариуцсан инженер.....

ХҮЛЭЭН АВСАН:

1.УУА-ны мэргэжилтэн.....

2.ГУУУХА-ны улсын байцаагч.....

-----оо-----

АМХЭГ-ын дарга, ГУУУХА-ны даргын 1998 оны  
07-р сарын 09-ны өдрийн 153/11 тоот тушаалын 2 дугаар хавсралт

уурхайн оны  
хөдөлмөр хамгааллын хувцас, бие хамгаалах  
хэрэгсэл олголтын мэдээ

Д/д	Үзүүлэлт	онд	онд	Харьцуул -сан хувь
1	Хөдөлмөр хамгаалалын хувцас олговол зохих хүний тоо			
2	Үүнээс: олгосон			
3	Хамгаалах хэрэгсэл олговол зохих хүний тоо			
4	Үүнээс: олгосон хүний тоо			
Үүнээс	Нүдний шил			
	Чихэвч			
	Хормойвч			
	Маск			
	Бээлий			
	Каск			
	Гэрэл			
	Амь хамгаалах багаж СП-2			
	Метан хэмжигч			
	Усны гутал			
	Эсгий гутал			
	Кобинзон			
	Хөвөнтэй өмд цамц			
	Берзентэн өмд цамц			
	Өндөр хүчдэлийн тусгаарлагч штанг			
	Тусгаарлагч тавиур			
	Резинэн хйвс			
Резинэн бээлий				
Тусгаарлагч				
5.	Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам зөрчсөн хүний тоо			
Тэдгээрт Ногдуулсан арга хэмжээ	Торгууль			
	Сануулга			
	Албан тушаал, мэргэжлийн зэрэг бууруулсан Цалин, шагналыг бууруулсан			
6.	Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө /сая.төг/			

МЭДЭЭ ГАРГАСАН:

1. Ерөнхий инженер

2. Ня-бо

ХҮЛЭЭН АВСАН:

1. УУА-ны мэргэжилтэн

2. ГУУУХА-ны улсын байцаагч

Маягт № 14

АМХЭГ-ын дарга, ГУУУХА-ны даргын  
1998 оны 07-р сарын 09-ны өдрийн  
153/11 тоот тушаалын 3 дугаар хавсралт

уурхайн 19 оны  
хөдөлмөр хамгаалалын ажлын зохион байгуулалт,  
сургалт, ахуй хангамж, эмнэлэг үйлчилгээний ажлын судалгаа

Үзүүлэлт		Д/д	Он
01		02	03
XX*, ХЭА**, АА ***-ны асуудал хариуцсан алба, хүний тоо		01	
XX, ХЭА, АА-ны дүрэмтэй эсэх		02	
XX, ХЭА, АА-ны кабинеттай эсэх		03	
XX, ХЭА, АА-ны сургалтын батлагдсан хөтөлбөртэй эсэх, хөтөлбөртэй бол хэдэн цагийн		04	
XX-ын сургалтанд хамрагдсан хүний тоо		05	
Үүнээс:	Урьдчилсан зааварчилгаа	06	
	Ажлын байрны анхан шатны	07	
	Давтан зааварчилгаа	08	
Ажиллагсдын ахуйн байрны хүрэлцээ, хангамж	Хувцас солих өрөөний тоо	09	
	Хувцасны шүүгээний тоо	10	
	Халуун усны шүршүүрийн тоо	11	
	Дулаацах, амрах байрны суудлын тоо	12	
Ажиллагсдын хооллолт	Бие засах газрын суудлын тоо	13	
	Гуанз, цайны газрын суудлын тоо	14	
Хоолны үний хямдралт /хувиар/		15	
Хжинчдыг жилд хэдэн удаа эрүүл мэндийн үзвэгт оруулдаг		16	
Гэрээтэй ажилладаг эрүүл мэндийн байгууллагатай эсэх		17	
Хөдөлмөрийн чадвар түр алдалтын жилийн дундаж хэмжээ хүн-өдөр		18	
Мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн хүний тоо		19	
Үүнээс: өвчний төрөл тус бүрээр	Уушиг тоосжих /силикоз, өнтрокоз, пневлюканиоз/	20	
	Гуурсан хоолойн архаг үрэвсэл	21	
	Гуурсан хоолойн багтраа	22	
	Дүлийрэлт	23	
		24	
		25	
Мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас ажлаа өөрчилсөн хүний тоо		26	
Үүнээс хэдэн хүн ажлын байраар хангагдсан		27	
Мэргэжлийн хордлого гарсан эсэх, гарсан бол хэдэн удаа		28	
Мэргэжлийн хордлогод хамрагдсан хүний тоо		29	
Ажлын байрны нийт тоо		30	
Үүнээс: Хөдөлмөрийн нөхцөлийн	Хэвийн	31	
	Газрын дор	32	
	Хортой	33	

ангилал тус бүрээр	Хүнд	34
	Халуун	35
Хөдөлмөрийн нөхцөлд нөлөөлж буй хүчин зүйл нь эрүүл ахуйн нормтой тохирохгүй байгаа ажлын байр	Гэрэлтүүлэг хангалтгүй	36
	Чийглэгтэй	37
	Тоосжилттой	38
	Дуу шуугиантай	39
	Доргионтой	40
	Химийн бодисын ууршилттай	41
	Цахилгаан соронзон нөлөөнд ажилладаг	42
	Цацраг идэвхит бодистой харьцан ажилладаг	43
	Өндөр хэмтэй халуунд	44
	Сүү болон саармагжуулсан зүйл хэрэглэдэг	45
Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагсдад эдлүүлж буй хөнгөлөлт /хүний тоогоор/	Хямдруулсан хоолтой	46
	Хорогдуулсан цагтай	47
	Уртасгасан ээлжийн амралттай	48
	Нэмэгдэл хөлс авдаг	49

Тайлбар: \* Хөдөлмөр хамгаалал  
 \*\* Хөдөлмөрийн эрүүл ахуй  
 \*\*\* Аюулгүй ажиллагаа

СУДАЛГАА ГАРГАСАН:

1. Ерөнхий инженер
2. ХХ-ын инженер
3. Ня-бо

ХҮЛЭЭН АВСАН:

1. УУА-ны мэргэжилтэн
2. ГУУУХА-ын улсын байцаагч

-----oOo-----

АМХЭГ-ЫН ДАРГА, ГУУУХА-НЫ ДАРГЫН  
 ХАМТАРСАН ТУШААЛ

1998 оны 7 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 154/12

Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

"Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах" Үндэсний хөтөлбөрийг уул уурхайн үйлдвэрлэл, геологийн судалгаа, хайгуулын ажил эрхэлдэг үйлдвэр, аж ахуйн нэгжид хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах" Үндэсний хөтөлбөрийг 1998-2000 онд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, "Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах талаар зохион байгуулах ажлын үндсэн чиглэл"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан ажлын төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байхыг албадын дарга, ахлах байцаагч нарт даалгасугай.

ДАРГА  
 Д.ЖАРГАЛСАЙХАН

ДАРГА  
 Д.ЧИЛХААЖАВ

-----oOo-----

**Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөрийн аюулгүй  
ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах талаар  
зохион байгуулах ажлын үндсэн чиглэл**

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах  
Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уурхай, аж ахуйн нэгж,  
дараахь ажлыг зохион байгуулна. Үүнд:

1. Үйлдвэрлэл, ажлын онцлогт тохируулан техник, тоног төхөөрөмжийн  
ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг аж ахуй эрхлэх орчин үеийн  
шаардлагын дагуу шинэчлэн боловсруулж мөрдөх,  
/1998 оны 4-р улирал

2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг хариуцсан алба  
/ажилтан/-ыг ажиллуулж, тэднийг ажлын тодорхой удирдлагаар хангах,  
/1998 оны 3-4-р улирал

3. АМХЭГ-ын дарга, ГУУУХА-ны даргын 1998 оны 153/11 тоот тушаалаар  
батлагдсан маягтын дагуу мэдээ, судалгаа гаргаж түүнд үнэлэлт дүгнэлт өгөхийн  
үндсэн дээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан  
сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллах,  
/1998 оны 3-4-р улирал

4. Хөдөлмөрийн хүнд, хортой, газрын дор болон аюултай нөхцөлтэй ажлын  
байранд ажилладаг ажиллагсад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны ажлын 5-аас  
доошгүй өдрийн тусгай сургалт зохион байгуулж, ажиллах эрх олгох ажлыг  
мэргэжлийн болон хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах,  
/1998 оны 4-р улирал

5. Ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслийн хангамжийг норм,  
нормативын дагуу сайжруулах, тэдгээрийн гоо зүйн үзэмжийг дээшлүүлэх, эдлэх  
хугацааг уртасгах арга хэмжээг зохион байгуулах,  
/1998 оны 4-р улирал, 1999 оны 2-р улирал

6. Өөрийн боломжид тулгуурлан үйлдвэрийн эмчтэй болох, эсхүл эмнэлгийн  
байгууллагатай гэрээтэй ажиллах замаар ажиллагсдаа эмнэлгийн үзлэгт тогтмол  
хамруулах  
/Жил бүр

7. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар тэргүүний ажлын  
байрыг шалгаруулж, урамшууллын систем тогтоож мөрдүүлэх,  
/1998 оноос эхлэн жил бүр

8. Эрсдэл ихтэй үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөрийн  
аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр авах арга хэмжээний дэд хөтөлбөр  
төсөл боловсруулж хэрэгжүүлэх,  
/1998 оны 4-р улирал, 2000 оны 4-р улирал

9. Үйлдвэрлэлийн ажиллагсад зориулан хөдөлмөрийн хууль тогтоомж,  
хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, журам, стандарт зэрэг  
асуудлаар холбогдох байгууллагатай хамтран ажлын 3-аас доошгүй өдрийн  
сургалт зохион байгуулах,  
/1998 оны 4-р улирал-2000 оны 4-р улирал

10. Техник, тоног төхөөрөмж, өргөх зөөх механизмын бүрэн бүтэн байдлыг  
хангаж, арчилгаа, үзлэг, засвар үйлчилгээний чанарт хяналт тавих,  
/Жил бүр

11. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд нөлөөлөх хүчин зүйлүүдийг хэвийн  
хэмжээнд байлгах, үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах  
хэрэгслээр бүрэн хангах,  
/Жил бүр

12. Ажиллагсад хөдөлмөрийн нөхцөлтэй холбогдсон хууль тогтоомжид  
заасан зохих хөнгөлөлт, нөхөн олговор, шагналыг олгож байх,  
/Жил бүр

13. Ахуйн байрыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын хэмжээнд нийцүүлэн  
тохижуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, жил бүр ХНХУ Алба болон Эрүүл  
ахуй, халдвар судлалын хяналтын албадаар хэмжилт хийлгүүлэх /тоосжилт,  
хуурайшилт, гэрэлтүүлэг гэх мэт/

14. Энэхүү үндсэн чиглэлийн зүйл тус бүрээр зохиосон ажлын тайланг жил  
жур мэдээ, судалгааны хамт АМХЭГ-т ирүүлнэ.

-----o o-----